



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584  
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.04.20

№

1/290

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ Г  
ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА Г

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна.

Аудитаар хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримтын хамт 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт <sup>38</sup>...хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

005030503

D/2023-A5.doc

Б.БАТЛАВ  
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭСИЙН  
ДАРГА



2022 оны 05 дугаар сарын 22

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН  
ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ТӨЛӨВЛӨГӨӨ

Дд	Гарсан зөвлөмж	Авах арга хэмжээ	Хариуцах эзэн
1	2	3	4
1	<p>Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг аймгийн ИТХ-аар батлуулж, мөрдүүлээгүй байна.</p> <p>Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх "Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал тогтооно" гэсэн заалтыг зөрчсөн байна.</p> <p>Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах</p>	<p>Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн гүйцэтгэх захирал ба бусад албан хаагчид олгох цалин хөлсний жишгийг тогтоож, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах тухай албан тоотыг Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэх.</p>	<p>Санхүү, төрийн сангийн хэлтэс Ш.Гэрэлсүх</p>
2	<p>Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд бүртгэлтэй 4 өрхийн эмнэлгийн нийт 1045,3 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий хөрөнгийг тайлант онд бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн балансаас хассан ч тус хөрөнгүүд нь Эрүүл мэндийн яаманд нэгтгэгдээгүй байна.</p> <p>Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр</p>	<p>2023 оны хагас жилийн санхүүгийн тайлангаар Сангийн яамнаас гарсан шийдвэрийн дагуу бүртгэнэ.</p>	<p>Санхүү, төрийн сангийн хэлтэс Ц.Самбууням</p>

1	2	3	4
	<p>зүйлийн 14.4.2 дахь “Нягтлан бодох бүртгэл бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.</p> <p>Шийдвэрлэсэн нь: Тус орон нутгийн өмчийн хөрөнгийг цаашид хэрхэн бүртгэх талаар шийдвэрийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.</p>		
3	<p>Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нөөцийн бараа дансанд нийт 8,369,5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас 7,266,8 сая төгрөг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн их засвар, аймаг, Баянхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжсэн, дутуу хэрэгжсэн, хөрөнгийн эзэмшигчийг тогтоосон шийдвэр нь гараагүй төсөл, арга хэмжээний санхүүжилт байна.</p> <p>Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 20.2.6 дэх “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.</p> <p>Шийдвэрлэсэн нь: Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгийн эзэмшигчийг тогтоох асуудлыг цаг тухайд нь эрх бүхий байгууллагад тавьж, шийдвэрлүүлж байх.</p>	<p>Нөөцийн бараагаар бүртгэсэн хөрөнгийг 2023 оны хагас жилийн тайлан гаргалтаар эзэмшигчийг тогтоож, 2023 оны ИТХ-аар шийдвэрлүүлэх тухай албан тоотыг хөрөнгийн жагсаалтын хамт Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх</p>	<p>Санхүү, төрийн сангийн хэлтэс Ц.Самбууням</p>
4	<p>Богд сумын ЗДТГ, ИТХ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу төсөвт байгууллагууд нь санхүүгийн тайлангаа хугацаанд нь ирүүлээгүй, орон нутгийн төсөвт байгууллагууд хариуцсан нягтлан бодогчийг ажлаа хаяж явсан гэх боловч Улаанбаатар хотоос цалингийн болон зардлын гүйлгээг он дуустал хийсэн байхад шат шатны хяналтыг хэрэгжүүлээгүй байна.</p> <p>Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49 дэх</p>	<p>Богд сумын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нягтлан бодогч Пүрэвсүрэнг ажлаас нь чөлөөлсөн. Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журмын дагуу нягтлан бодогчийг томилох.</p>	<p>Санхүү, төрийн сангийн хэлтэс Ш.Гэрэлсүх</p>

1	2	3	4
	“дотоод аудит” гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг” гэсэн заалтыг зөрчсөн байна.		

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ТӨЛБӨР  
ТООЦОО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



С.ЦЭВЭЭНСҮРЭН



БЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА С.БАЙГАЛМАА  
2022 оны... дугаар сарын...

БЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН  
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТЫН АЛБАН ШААРДЛАГЫГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дд	Албан шаардлага	Авах арга хэмжээ	Хариуцах эзэн
1	2	3	4
1	<p>Баянхонгор аймгийн Засаг даргын харьяа төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тус байгууллагууд нь авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байхад тооцоо нийлсэн актгүйгээр бүртгэсэн, мөн тайлант онд үүссэн болон 5-аас бага жилийн насжилттай авлагын насжилтыг буруу бүртгэсэн, мөн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг дутуу бүртгэсэн зэргээр нягтлан бодогч нар Э-тайланд авлагын тодруулгыг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй байхад түүнд хяналт тавиагүй байна.</p> <p>Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3 дахь “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана.”, Нягтлан боох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9 дахь “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь, үнэн зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.</p> <p>Шийдвэрлэсэн нь: Сангийн яамны Э-тайланд авлагын тодруулга тайланг буруу бүртгэсэн зөрчлийг арилгаж, цаашид үнэн зөв бүртгэж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.</p>	<p>2023 оны хагас жилийн санхүүгийн тайлан гаргалтаар аймгийн төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланд авлагын насжилтыг залруулан бүртгүүлэх.</p>	<p>Санхүү, төрийн сангийн хэлтэс Ц.Самбууням</p>

1	2	3	4
2	<p>Төсөвт байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглаж байсан 44 автомашиныг аймгийн Орон нутгийн өмчийн газарт татан төвлөрүүлж, аймгийн Засаг даргын 2023.03.20-ны өдрийн А/147 дугаар захирамжаар 20 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, 6 автомашиныг акталж, 10 автомашиныг автомашин дутагдалтай төсөвт байгууллагуудад балансаас баланст шилжүүлэхээр шийдвэрлэснээс 28 байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 34 тээврийн хэрэгслийг Орон нутгийн өмчийн газарт 2023.03.25-ны өдрийн байдлаар ирүүлээгүй байна.</p> <p>Энэ нь Засгийн газрын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын 2 дахь “Энэ тогтоолын 1-д заасны дагуу татан төвлөрүүлсэн төрийн өмчид бүртгэлтэй суудлын автомашиныг “Засгийн газрын автобааз” УТҮГ-т, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашиныг тухайн аймаг, нийслэлийн харьяа автотээврийн байгууллагад шилжүүлж, төрийн болон орон нутгийн байгууллагын нийтлэг үйлчилгээний хүрээнд дуудлагын автомашины зориулалтаар ашиглуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай” гэсэн заалттай нийцэхгүй байна.</p> <p>Шийдвэрлэсэн нь: Тус автомашинуудыг татан төвлөрүүлж Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.</p>	<p>2023 оны хагас жилийн байдлаар татан төвлөрүүлээгүй 25 тээврийн хэрэгслийг Орон нутгийн өмчийн хашаанд төвлөрүүлж Аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэр гаргуулж ажиллах талаар Орон нутгийн өмчийн газарт албан тоот хүргүүлэх</p>	<p>Санхүү, төрийн сангийн хэлтэс Ц.Самбууням</p>
3	<p>Аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 156 мэдээллээс 84 мэдээллийг хугацаанд нь, 57 мэдээллийг хугацаа хоцроож, 13 мэдээллийг мэдээлээгүй байна.</p> <p>Энэ нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь “Төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар”, 6.4.5 дахь “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, 6.4.8 дахь “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн.</p>	<p>Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны мэдээлэл оруулах төлөвлөгөөг гарган Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаар батлуулан ажиллах.</p>	<p>Санхүү, төрийн сангийн хэлтэс Г.Должинсүрэн</p>

1	2	3	4
	<p>гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, гэсэн заалтуудыг зөрчсөн байна.</p> <p>Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй мэдээллийг нөхөн мэдээлж, зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв</p>		

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:  
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ТӨЛБӨР  
ТООЦОО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



С.ЦЭВЭЭНСҮРЭН

Б. БАТЛАВ  
 САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН  
 ДАРГА С. БАЙГАЛМАА  
 оны... Дугаар сарын...



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН  
 ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН НИЙТЛЭГ АЛДАА, ЗӨРЧЛИЙГ  
 ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дд	Гарсан зөвлөмж	Авах арга хэмжээ	Хариуцах эзэн
1	2	3	4
1	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийг Төрийн сан дахь 100030000972 тоот харилцах дансны гүйлгээтэй тулган шалгахад 2022 онд 17,126,2 сая төгрөгийн дэмжлэгийг хүлээн авч Сангийн сайдын 2022.02.08-ны өдрийн 33 дугаар “Дамжуулан зээлдүүлсэн зээлийн өр төлбөрийг суутган тооцох тухай” албан бичгийг үндэслэн /OL-2301MON-04 дугаарт зээл/ 483.2 сая төгрөгийн үндсэн зээл, 65,6 сая төгрөгийн хүү, нийт 548,8 сая төгрөгийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс суутган тооцсон байна. Үүнээс шалтгаалж 8 сумын санхүүгийн дэмжлэг 184,4 сая, аймгийн төсөвт орох санхүүгийн дэмжлэг 364,4 сая төгрөгөөр дутуу орсон байна. Энэ нь өмнөх онуудад Төрийн аудитын газраас тухайн зээлийг ТЕЗ-ийн санхүүгийн тайлан тусгах, орон нутгийн давсан орлогоос тус зээлийн төлбөрийг төлж, зээлийн эрсдэлийг бууруулах зөвлөмжийг өгч байсан боловч түүнийг анхаарахгүй, хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан байна.	Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдээс орох орлогыг тухай бүрт төвлөрүүлж ажилласны үндсэн дээр Сангийн яамтай хийсэн зээл төлөлтийн хуваарийн дагуу зээлийн төлөлтийг хийж ажиллах.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч Ц.Самбууням
2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй харилцан тохиролцож, уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг 12 аж ахуйн нэгжтэй тайлант онд Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулж аймагт 2,265,0 сая, сумдад 1,230,0 сая төгрөг, нийт 3,570,0 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Аймагт оруулах хөрөнгө оруулалтаар 2022 онд 1,465,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт,	Төсвийн тухай хууль болон ашигт малтмалын тухай хуульд 2022.11.11-ний өдөр нэмэлт өөрчлөлт орж уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс төвлөрөх хандив, тусламжийг орон нутгийн хөгжлийн сангийн бүрдэл	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн



1	2	3	4
	их засвар, гудамж талбайн тохижилт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Дээрх хөрөнгө оруулалт нь аймгийн орон нутгийн төсвийн дансаар дамжуулаагүй, өмнөх онд ТЕЗ-ийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил давтан гарсан байна.	хэсэг гэж үзэхээр болсон. Уг өөрчлөлтийн дагуу 2023 оны аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд 2,500,0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөж, Аймгийн ИТХ-ын хурлын хуралдаанаар баталсан.	Б.Намуун
3	Аймгийн Татварын хэлтсийн 2022 оны тайлангаар татварын орлогын гүйцэтгэлийг 21,808,6 сая төгрөгөөр буюу аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас 123,3 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.	Төсвийн орлогын мэдээг төсвийн тухай хуулийн дагуу тухайн тайлант хугацаанд орсон орлогыг мөнгөн сууриар бүртгэж, татварын мэдээг авах талаар аймгийн татварын хэлтэстэй зөвшилцөж ажиллах.	Орлогын мэргэжилтэн Ш.Даваабат
4	Сумын ИТХ-аар тодотгон баталсан тогтоолын өөрчлөлтийг тухай бүр санхүүгийн төлөвлөлтийн программд оруулан зөв нэгтгэж байх.	Сумын ИТХ-аар тодотгон баталсан тогтоолын өөрчлөлтийг тухай бүр санхүүгийн төлөвлөлтийн программд оруулан, үнэн зөв нэгтгэж ажиллах	Төсвийн мэргэжилтэн Б.Жамъяндорж
5	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хийгдсэн төсөл, арга хэмжээний зураг төсвийн авлагын үлдэгдлийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах	ХБТХО-ын хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэнтэй хамтран өмнөх хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг тулган, зураг төсвийн авлагыг үнэн зөв тодорхойлж, авлагаар бүртгэхгүй зураг төсвийн тооцоог бүртгэлээс аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн бүртгэлээс хасах.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч Ц.Самбууням
6	Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны цахим сайтад байршуулаагүй.	Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны цахим сайтад байршуулж ажиллах талаар заавар, зөвлөгөө өгч ажиллах	Төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн С.Цэвээнсүрэн

1	2	3	4
7	Сумдын санхүүгийн албаны дарга нарын ажлын хариуцлагыг сайжруулах	Сумдын санхүүгийн албаны дарга нарт Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг зөв оруулах талаар сургалт, мэдээлэл өгч ажиллах	Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч Ц.Самбууням

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ТӨЛБӨГ  
ТООЦОО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



С.ЦЭВЭЭНСҮРЭН